



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

Г Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг

батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дах заалтыг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Монголын талбарын тархвар судлал сургалтын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдах зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын /хуучин нэрээр /2013 оны 35 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т даалгасугай.

САЙД

ШИЙЛЭГДАМБА



Эрүүл мэнд, Спортын сайдын  
2015 оны 04 сарын 16..өдрийн  
145 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

МОНГОЛЫН ТАЛБАРЫН ТАРХВАР СУДЛАЛЫН СУРГАЛТЫН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Эрүүл мэнд, спортын дэд сайд

Орлогч дарга:

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын  
дарга

Нарийн бичгийн дарга:

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Гишүүд:

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн /НЭМХ/  
халдварт өвчиний хяналт, урьдчилан  
сэргийлэлтийн бодлогын хэрэгжилтийн  
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

НЭМХ-ийн халдварт бус өвчиний хяналт,  
урьдчилан сэргийлэлтийн бодлогын  
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан  
мэргэжилтэн

Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн эмнэлгийн  
дээд мэргэжилтний хөгжлийн бодлогын  
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан  
мэргэжилтэн

ЭМСЯ-ны тархвар судлалын ерөнхий  
мэргэжилтэн

Хүнс, хөдөө аж ахуйн яамны стратеги, бодлого  
төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн  
тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн  
захирал

Хавдар судлалын үндэсний төвийн эрдэмтэн  
нарийн бичгийн дарга

Эх нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн  
эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа  
эрхэлсэн дэд захирал

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн  
захирал

АШУҮИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн  
Сургуулийн захирал

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл  
мэндийн мэргэжилтний хөгжлийн хэлтсийн  
дарга

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мал  
эмнэлэг үргжлийн газрын ерөнхий  
эпидемиологч

Нийслэлийн эрүүл мэндийн газрын орлогч  
дарга

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн  
талбарын тархвар судлал сургалтын албаны  
дарга

Монгол дахь ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн  
газрын мэргэжилтэн /зөвшилцснөөр/

Эрүүл мэнд, Спортын сайдын  
2015 оны 07 сарын 16 өдрийн  
145 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монголын талбарын тархвар судлалын сургалтын удирдах зөвлөл (цаашид “Удирдах зөвлөл” гэнэ)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Удирдах зөвлөл нь Монголын талбарын тархвар судлалын сургалтад бодлогын дэмжлэг үзүүлэх орон тооны бус зөвлөл байна.
- 1.3. Удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн хууль болон бусад хууль тогтооомжийг мөрдлөг болгон ажиллана.

### Хоёр. Удирдах зөвлөлийн чиг үүрэг

Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 2.1. Монголын талбарын тархвар судлалын сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, бодлогын зөвлөгөө өгөх,
- 2.2. Монголын талбарын тархвар судлалын сургалтай холбоотой үйл ажиллагааны бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах
- 2.3. Талбарын тархвар судлал сургалтын цаашдын сургалтын тогтвортой байдлыг хангах хөгжлийн стратегийг тодорхойлох,
- 2.4. Сургалтын үйл ажиллагааг сурталчлах, хамтрах ажиллагч Засгийн газрын, олон улсын болон бусад байгууллагуудын дэмжлэг, хамтын ажиллагааг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх,
- 2.5. Тухайн жилдээ элсэн суралцагчдын тоо, квот, чиглэлийг хэлэлцэн тодорхойлох,
- 2.6. Стратеги төлөвлөгөө болон жил бүрийн сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд зөвлөгөө өгөх, хэлэлцэн батлах,
- 2.7. Сургалтын үйл ажиллагааны жилийн тайлланг хэлэлцэх, зөвлөгөө өгөх,
- 2.8. Суралцагсад болон төгсөгчдийг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед дайчлан оролцуулах шийдвэр гаргах.

### Гурав. Удирдах зөвлөлийн хурлын дэг

Удирдах зөвлөл нь хагас жилд 1 удаа хуралдана. Удирдах зөвлөлийн дарга шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

- 3.1. Удирдах зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудал, хөтөлбөр, холбогдох материалыг 7 хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд хүргүүлсэн байна.
- 3.2. Удирдах зөвлөлийн гишүүн хэлэлцэх асуудлыг санаачилж болно.
- 3.3. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан тухайн хариуцаж байгаа байгууллагын төлөөлөгчийг оролцуулж болно.
- 3.4. Удирдах зөвлөлийн гишүүд 70 хувийн ирцтэй оролцсон хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

- 3.5. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг дийлэнх олонхийн саналаар гаргана.
- 3.6. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг хурал даргалагчийн гарын үсгээр баталгаажуулна.
- 3.7. Удирдах зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмж, шийдвэрийг нарийн бичгийн дарга холбогдох байгууллагад нээлттэй хүргүүлнэ.